



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

23 оны 08 сарын 07 өдөр

Дугаар а/495

Арвайхээр сум

Комисс томилох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 49 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад авах журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өвөрхангай аймгийн Арвайхээр хотын Шинэ суурьшлын бүсийн цэцэрлэгт хүрээлэнгийн доторх тохижолтын ажил /унадаг дугуйн зам/-ыг байнгын ашиглалтад хүлээн авах комиссын бүрэлдэхүүнийг хавсралтаар тус тус баталсугай.

2.Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 49 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад авах журам”-ыг тус тус хэрэгжүүлж ажиллахыг барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дарга (Б.Мөнхбат)-д даалгасугай.

ОРЛОГЧ

И.ДОРЖСҮРЭН



6223 11 0980

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны... дугаар
сарын 07-ны өдрийн 00:00 дугаар
захирамжийн хавсралт



**АВТО ЗАМЫН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ
КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН**

Комиссын дарга:

Б.Мөнхбат (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын
хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд:

Ц.Алтан-Эрдэнэ (Өвөрхангай аймаг дахь Цагдаагийн
Газрын Замын цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн
хошууч)
Ц.Нэргүй (Архивын тасгийн дарга, Архив, албан
Хөтлөлтийн хяналтын улсын байцаагч)
Холбогдох сумын төлөөлөл
Гүйцэтгэгч аж ахуй нэгжийн төлөөлөл

Нарийн бичгийн дарга: Б.Цогтбаатар (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Авто замын хяналтын улсын байцаагч)

-оОо-